



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

Нийцлийн аудитын тайлан

Аймгийн ИТХ-ын 2016 оны сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын зарцуулалт



2016 он

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ИТХ-ЫН 2016 ОНЫ СОНГУУЛЬД ОРОЛЦСОН НАМ, ЭВСЭЛ, НЭР ДЭВШИГЧИЙН СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ЗАРЦУУЛАЛТАД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

2016.10.27

Нэг. Эрх зүйн үндэслэл

Аймгийн ИТХ-ын 2016 оны сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигч нь Сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.3, 59 дүгээр зүйлийн 59.1-д заасны дагуу сонгуулийн зардлын тайланг гаргаж ирүүлэх үүрэгтэй бөгөөд Төрийн аудитын байгууллага Сонгуулийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3, 60.4-т заасны дагуу сонгуулийн зардлын тайланг хянах эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

Аймгийн ИТХ-ын сонгуульд Монгол ардын нам, Ардчилсан нам, Монгол ардын хувьсгалт намууд оролцсон байна. МАН болон АН-аас тус бүр 17 нэр дэвшигч оролцсон байна. Сонгуульд нийт 34 менежер, 101 шадар туслах, 234 ухуулагч нар ажилласан байна.

Хоёр. Сонгуулийн зардлын эх үүсвэрийн талаар

Аймгийн ИТХ-ын 2016 оны сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигч нь Сонгуулийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2-д зааснаар сонгуулийн зардалд зарцуулах хөрөнгийн эх үүсвэрийг хандив, нэр дэвшигчийн өөрийн хөрөнгө болон намын өөрийн хөрөнгөөс бүрдүүлэхээр заасан байна.

Аймгийн ИТХ-ын 2016 оны сонгуульд Монгол ардын нам 23,000.0 мянга, Ардчилсан нам 10,900.3 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлсэн байна.

Аймгийн ИТХ-ын 2016 оны сонгуульд Монгол ардын намаас 17 нэр дэвшигч, Ардчилсан намаас 17 нэр дэвшигч тус тус оролцсон байна.

Сонгуулийн зардалд Монгол ардын намаас нэр дэвшигчид нийт 66,350.3 мянга, Ардчилсан намаас нэр дэвшигчид нийт 48,281.3 мянган төгрөгийн эх үүсвэрийг тус тус бүрдүүлсэн байна.

Хоёр. Сонгуулийн зардлын зарцуулалтын талаар

Аймгийн Аудитын газраас ИТХ-ын 2016 оны сонгуульд зарцуулах зардлын дээд хэмжээг аймгийн Тэргүүлэх аудиторын 2016 оны А/04 тоот тушаалаар баталж, нам, эвсэл тус бүрийн сонгуульд зарцуулах зардлын дээд хэмжээг 35.1 сая, нэг нэр дэвшигчийн тойрог тус бүрт зарцуулах зардлын дээд хэмжээг 6.7-7.8 сая төгрөгөөр тус тус тогтоосон байна.

Монгол ардын нам сонгуулийн зардалд 23.0 сая, Ардчилсан нам 10.9 сая төгрөгийг тус тус зарцуулсан бөгөөд аймгийн Аудитын газраас тогтоосон сонгуулийн зардлын дээд хэмжээг хэтрүүлээгүй байна.

Аймгийн ИТХ-ын 2016 оны сонгуульд Монгол ардын нам болон Ардчилсан намаас тус бүр 17 нэр дэвшигч оролцсон байна. Нэр дэвшигчид Сонгуулийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.5-д “Аймаг, нийслэлийн хурлын сонгуульд нэр дэвшигч нь сонгуулийн зардлын данс нээлгэсэн өдрөөс хойш тав хоногийн дотор аймаг, нийслэлийн сонгуулийн хороонд дансны дугаар, банкны нэрийг мэдэгдэж бүртгүүлэх үүрэгтэй” гэснийг үндэслэн нэр дэвшигч тус бүрээр Капитал, ХААН болон Төрийн банкинд данс нээж, сонгуулийн зардлын дансандаа өөрийн хөрөнгө, хандивыг хуримтлуулан зарцуулсан байна.

Монгол ардын намын нэг нэр дэвшигч 2.3-5.5 сая, Ардчилсан намын нэг нэр дэвшигч 1.7-4.7 сая төгрөгийг сонгуулийн зардалд тус тус зарцуулж, аймгийн Аудитын газраас тогтоосон зардлын дээд хэмжээг хэтрүүлээгүй байна.

Сонгуулийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3-д заасны дагуу нэр дэвшигчдэд 1.0 сая төгрөг ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн 27 иргэний 42,130.0 мянган төгрөгийн хандивыг нийтэд ил тод мэдээллээ.

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ИТХ-ЫН 2016 ОНЫ СОНГУУЛЬД НЭР ДЭВШИГЧДЭД
ИРГЭДЭЭС ӨГСӨН ХАНДИВЫН ЖАГСААЛТ**

2016.11.03

№	Иргэдийн нэрс	Оршин суугаа газрын хаяг	Мөнгөн хандивын дүн
1	Д.Мөнгөнцэцэг	УБ хот,Баянзүрх дүүрэг, Кристал таун 801-101 тоот	2 000 000
2	Д.Бээжин	ГСА, Сүмбэр сум, 3-р баг 3-2-29 тоот	1 000 000
3	З.Одончимэг	УБ хот, Баянгол дүүрэг,6-р хороо 40-21 тоот	1 000 000
4	С.Энхмаа	ГСА, Сүмбэр сум, 3-р баг 1-116 тоот	1 400 000
5	Ч.Бат-Эрдэнэ	ГСА, Сүмбэр сум, 3-р баг 15-40 тоот	1 000 000
6	Д.Нансалмаа	ГСА, Сүмбэр сум, 4-р баг Хавирга	1 000 000
7	А.Эрдэнэбат	УБ хот, Баянзүрх дүүрэг, 26-р хороо, Кристал таун 802-806 тоот	2 200 000
8	Д.Чулуундорж	ГСА, Сүмбэр сум, 2-р баг Цагаан усны 2-6 тоот	2 000 000
9	Э.Алтанзул	ГСА, Сүмбэр сум, 3-р баг Баянхошуу 4-2 тоот	1 500 000
10	Ц.Хүдэрчулуун	УБ хот, СХ дүүрэг, 7-р хороо, 12-13 тоот	2 000 000
11	Д.Отгонбаяр	ГСА, Сүмбэр сум, 3-р баг 2-60 тоот	1 900 000
12	А.Алтансоёмбо	ГСА, Сүмбэр сум, 2-р баг Рашааны 21 тоот	1 000 000
13	Б.Мөнхболд	УБ хот, ЧД, 7-р хороо, Хувьсгалчдын Г-18-ийн 410 тоот	1 500 000
14	Д.Өнөржаргал	ГСА, Сүмбэр сум, 3-р баг 4-127 тоот	2 000 000
15	Т.Түмэнбаяр	ГСА, Сүмбэр сум, 3-р баг 15-54 тоот	1 000 000
16	Т.Оюундэлгэр	ГСА, Сүмбэр сум, 1-р баг ТЗ-ын 124-1 тоот	2 100 000
17	Ө.Отгонбаяр	УБ хот, БЗД, 23-р хороо, 3-В хэсэг 536 тоот	2 430 000
18	Б.Нямцэцэг	УБ хот, СБД, 3-р хороо, 5-р хороолол, 57-40 тоот	1 500 000
19	У.Чулуунцэцэг	ГСА, Шивээговь сум, 1-р баг 12-2-23 тоот	1 000 000
20	А.Цогтжав	УБ хот, СБД, 8-р хороо, 54-17 тоот	1 000 000
21	Л.Цацрал	УБ хот, БГД, 1-р хороо, 57-70 тоот	2 900 000
22	С.Одбаяр	Шивээговь сум 1-р баг, 13-4 тоот	1 800 000
23	Д.Батзул	Шивээговь сум 1-р баг, 6-5-69 тоот	1 100 000
24	Б.Батбаяр	Шивээговь сум 1-р баг, 7-3-17 тоот	1 500 000
25	Л.Пүрэвээ	Шивээговь сум 1-р баг, 10-3-37 тоот	1 200 000
26	Ц.Эрдэнэчимэг	Хэнтий аймаг, Өмнөдэлгэр сум, 1-р баг, Айргийн энгэр 6 тоот	1 700 000
27	Ц.Эрдэнэболор	Багануур дүүрэг, 4-р хороо, Байдлагын 3-14 тоот	1 400 000
Дүн			42 130 000

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР